



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 10.

Чингис хот

Татварын хэлтсийн Баян-Овоо сумын
татварын улсын байцаагчийн сул
орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 2019 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, 2020 оны 141 дүгээр “Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /90/ авсан Батаагийн Ундрахцэцэгийг Татварын хэлтсийн Баян-Овоо сумын татварын улсын байцаагчийн сул орон тоонд нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Ундрахцэцэгийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Татварын хэлтсийн дарга /А.Гантөмөр/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Татварын хэлтсийн даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР